

НИЙЦЛИЙН АУДИТ

АУДИТЫН СЭДЭВ: СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДСОН УЛСЫН
ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛ

АУДИТЫН КОД: ГНАГ-2024/06-ШТА-НА

АЙМГИЙН СОНГУУЛИЙН ХОРОО НЬ СУМДЫН СОНГУУЛИЙН ХОРООДОД ХУВААРИЛСАН
ТӨСВИЙГ ДУТУУ САНХҮҮЖҮҮЛЖ, УГ ЭХ ҮҮСВЭРЭЭР УНААНЫ БОЛОН ТОМИЛОЛТЫН
ЗАРДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭТРҮҮЛЭН ЗАРЦУУЛСАН БАЙНА

Сүхбаатар сум

2024 он

Дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа

Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn

Аудитын менежер Б.Батмөнх

Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn

Ахлах аудитор Т.Болор

Утас: 70362442 Цахим хаяг: bolort@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой мэдээллийг

дараах хаягаар авна уу: Цахим хуудас: www.audit.mn

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар

Хүснэгт, дүрслэл, хавсралтын товъёг

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл

Ерөнхий мэдээлэл

Бүлэг 1. УИХ-ын сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн хөрөнгийг хууль, журмын дагуу төлөвлөж, хуваарилсан эсэх?

1.1. Улсын төсвөөс олгох хөрөнгийн хэрэгцээ, шаардлагыг бодитой тооцсон уу?

1.2. Сонгуулийн хороодод төсвийг үндэслэлтэй хуваарилсан уу?

1.3. Сонгууль зохион байгуулахтай холбоотой зарим төрийн захиргааны байгууллагууд төсвийг үндэслэлтэй төлөвлөсөн үү?

Бүлэг 2. УИХ-ын сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг зориулалтын дагуу арвилан хэмнэлттэй зарцуулсан эсэх?

2.1. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу, арвилан хэмнэлттэй зарцуулсан уу?

2.2. Зардлын гүйцэтгэлийг бодитой тайлагнасан уу?

2.3. Сонгуулийн зардлын зарцуулалтад хяналт хэрэгжүүлсэн үү?

ДҮГНЭЛТ

ЗӨВЛӨМЖ

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
МТБ	Мэдээлэл технологийн баг
МТД	Мэдээлэл технологийн даамал
СЕХ	Сонгуулийн ерөнхий хороо
УБЕГ	Улсын бүртгэлийн ерөнхий газар
УБХ	Улсын бүртгэлийн хэлтэс
УИХ	Улсын Их Хурал

Хүснэгтийн товъёг:

- Хүснэгт 1. Сэлэнгэ аймагт хуваарилсан санхүүжилт*
- Хүснэгт 2. Аймгийн сонгуулийн хорооноос хуваарилсан санхүүжилт*
- Хүснэгт 3. Аймаг, сумдын сонгуулийн хороонд олгосон санхүүжилт*
- Хүснэгт 4. УБЕГ-аас аймгийн УБХ-т хуваарилсан санхүүжилт*
- Хүснэгт 5. Аймаг, сумдын сонгуулийн хорооны зардлын гүйцэтгэл /аймаг, сумдаар/*
- Хүснэгт 6. УБХ-ийн зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл*
- Хүснэгт 7. Сонгуулийн зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл /зардлын нэр төрлөөр/*

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТЫН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2023 оны 08 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2023 оны А/162 дугаар тушаалыг тус тус үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт заасан төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийв.

Аудитын зорилт:

УИХ-ын 2024 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд аудит хийж, дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэв.

Аудитын зорилтыг хангахын тулд дараах дэд асуудлын хүрээнд аудитыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- УИХ-ын сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг хууль, журмын дагуу төлөвлөж, хуваарилсан эсэх;
- УИХ-ын сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг зориулалтын дагуу, арвилан хэмнэлттэй зарцуулсан эсэх.

Аудитын хамарсан хүрээ:

Аудитад аймаг, сумдын сонгуулийн хороо, аймгийн УБХ зэрэг байгууллагуудыг хамруулав.

Аудитын арга зүй:

Аудитыг АДБОУС-100, 400, 4000, Монгол Улсын Төрийн аудитын стандарт-Нийцлийн аудит MNS 6817-3:2020, Нийцлийн болон Санхүүгийн аудитын арга зүйг ашиглан улсын төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалтын талаар холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, тайлан, судалгаа, баримт материалд тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийх аудитын судалгаа, хөтөлбөр, арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудитын шалгуур үзүүлэлт:

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглав.

- Төрийн аудитын тухай хууль,
- Төсвийн тухай хууль,
- Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль,
- Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль,
- Сонгуулийн төв байгууллагын тухай хууль,
- Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хууль,
- Дээрх хуулиудтай нийцүүлэн гаргасан тогтоол, журам,

- Батлагдсан төсөв, төсвийн хуваарь.

Аудит хийх багийн бүрэлдэхүүн, хугацаа:

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа удирдаж, аудитын менежер Б.Батмөнх явцын болон чанарын хяналтыг гүйцэтгэн, ахлах аудитор Т.Болор, аудитор Б.Бат-Орших нар 2024 оны 07 дугаар сарын 08-наас 08 дугаар сарын 12-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэлээ.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ:

УИХ-ын 2024 оны ээлжит сонгуулийг 06 дугаар сарын 28-ны өдөр Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулсан байна.

СЕХ-ны 2024 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 23 дугаар тогтоолоор Сэлэнгэ аймгийн сонгуулийн хороог 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан бол аймгийн сонгуулийн хорооны 2024 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор сумдын сонгуулийн хороог тус бүр 5-7 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан байна.

Аймгийн сонгуулийн хороонд 9, сумдын сонгуулийн хороонд 95, хэсгийн хороодод 556, мэдээллийн технологийн 86 даамал, цагдаагийн байгууллагын ажилтан 124, улсын бүртгэлийн ажилтан 62 зэрэг нийт **932** төрийн албан хаагч ажилласан байна.

СЕХ-ноос аймгийн сонгуулийн хороонд **691,487.0** мянган төгрөгийн төсөв хуваарилж, санхүүжилтийг бүрэн олгосон байна.

УБЕГ-аас сонгогчдын нэрсийн жагсаалт хэвлэх, санал авах техник хэрэгслийг тээвэрлэх, сургалт зохион байгуулах, мөнгөн урамшуулал олгох, унаа, хоолны зардалд нийт **55,290.1** мянган төгрөгийг аймгийн УБХ-т хуваарилж, санхүүжүүлсэн байна.

БҮЛЭГ 1. АЙМГИЙН СОНГУУЛИЙН ХОРОО САНАЛЫН ХУУДАС, ТӨХӨӨРӨМЖ АВАХ, ХҮЛЭЭЛГЭН ӨГӨХ ЗАРДЛЫГ СУМДАД ДУТУУ ОЛГОСОН БАЙНА.

1.1. Сонгогчийн тоо, сонгууль зохион байгуулахад оролцох ажилтны тоо, сум, хэсгийн хороодын тоо зэрэг мэдээлэлд үндэслэн зардлын төсвийг хуваарилсан байна.

1.1.1 Сэлэнгэ аймагт 2024 оны УИХ-ын сонгуулийг зохион байгуулахад улсын төсвөөс олгох зардлын хэрэгцээ шаардлагыг сонгогчийн тоо, сонгууль зохион байгуулахад оролцох ажилтны тоо, сум болон хэсгийн хорооны тоо, тэдгээрийн байршил, хоорондын зай зэрэг бусад шаардлагатай мэдээлэлд үндэслэн тодорхойлж, төсвийг хуваарилсан байна.

1.1.2 Дээрх үзүүлэлтүүдийг үндэслэн хэсгийн хорооны гишүүдийн урамшуулал, хоол, унааны зардал, мэдээ дамжуулах зардлыг тооцоолж, төлөвлөсөн бол бичиг хэрэг, сургалт сурталчилгаа, шуудан холбооны зардлыг тогтмол байхаар тооцож, ирүүлсэн байна.

1.2. Сумдын сонгуулийн хорооны төсвийг төлөвлөснөөс дутуу олгосон байна.

1.2.1 СЕХ-ноос аймгийн сонгуулийн хороонд 5 удаагийн удирдамжийн дагуу нийт **691,487.0** мянган төгрөгийн санхүүжилтийг хуваарилсан байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 1. Сэлэнгэ аймагт хуваарилсан санхүүжилт /мянган төгрөг/

№	Зардлын нэр, төрөл	2024.04.16	2024.05.02	2024.05.21	2024.06.09	2024.06.18	Нийт
1	Сонгуулийн дүн мэдээны маягт, хэвлэмэл хуудас хэвлүүлэх зардал	300.0					300.0
2	Сонгуулийн бичиг баримт, техник хэрэгсэл болон сурталчилгааны материалыг аймаг, сумын сонгуулийн хороо, санал авах байранд хүргэх, буцаан татах авах зардал				38,288.0		38,288.0
3	Сонгуулийн автоматжуулсан систем ашиглахтай холбоотой гарах зардал	-	-	-	1,300.0	2,130.0	3,430.0
4	Санал авах байр бэлтгэх зардал			19,220.0			19,220.0
5	Сонгуулийн байгууллагын ажилтан, МТБ-ийн гишүүн, даамал, нөөц даамлын сонгууль зохион байгуулахтай холбогдсон сургалт, сурталчилгааны зардал	9,763.0	16,110.0	12,000.0	-	-	37,873.0
6	Сонгуулийн байгууллагын ажилтан болон мэдээллийн технологийн багийн гишүүн, даамлын тухайн сонгуулийн байгууллагад ажилласан хугацааны мөнгөн урамшуулал, хоолны зардал	-	-	-	-	496,836.0	496,836.0
7	Бичиг хэргийн зардал		10,990.0				10,990.0
8	Шуудан, холбооны зардал		12,850.0				12,850.0
9	Унааны зардал		54,180.0				54,180.0
10	Албан томилолтын зардал					11,568.0	11,568.0
11	Болзошгүй зардал					5,952.0	5,952.0
Нийт дүн		10,063.0	94,130.0	31,220.0	39,588.0	516,486.0	691,487.0

Эх сурвалж: Аймгийн сонгуулийн зардлын тайлан

1.2.2 Аймгийн сонгуулийн хорооны даргын 4 удаагийн захирамжаар **691,487.0** мянган төгрөгийн санхүүжилтийг аймаг, сумын сонгуулийн хороодод хуваарилсан байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 2. Аймгийн сонгуулийн хорооноос хуваарилсан санхүүжилт /зардлын нэр, төрлөөр/ /мянган төгрөг/

№	Зардлын нэр	2024.05.06	2024.05.23	2024.06.18	2024.06.21	Нийт
1	Сонгуулийн дүн мэдээны маягт, хэвлэмэл хуудас хэвлүүлэх зардал	300.0				300.0
2	Сонгуулийн бичиг баримт, техник хэрэгсэл болон сурталчилгааны материалыг аймаг, сумын сонгуулийн хороо, санал авах байранд хүргэх, буцаан татах авах зардал			38,288.0		38,288.0
3	Сонгуулийн автоматжуулсан систем ашиглахтай холбоотой гарах зардал	-	-	1,300.0	2,130.0	3,430.0
4	Санал авах байр бэлтгэх зардал		19,220.0			19,220.0
5	Сонгуулийн байгууллагын ажилтан, МТБ-ийн гишүүн, даамал, нөөц даамлын сонгууль зохион байгуулахтай холбогдсон сургалт, сурталчилгааны зардал	25,873.0	12,000.0	-	-	37,873.0
6	Сонгуулийн байгууллагын ажилтан болон мэдээллийн технологийн багийн гишүүн, даамлын тухайн сонгуулийн байгууллагад ажилласан хугацааны мөнгөн урамшуулал, хоолны зардал	-	-	-	496,836.0	496,836.0
7	Бичиг хэргийн зардал	10,990.0				10,990.0
8	Шуудан, холбооны зардал	12,850.0				12,850.0
9	Унааны зардал	54,180.0				54,180.0
10	Албан томилолтын зардал				11,568.0	11,568.0
11	Болзошгүй зардал				5,952.0	5,952.0
Нийт дүн		104,193.0	31,220.0	39,588.0	516,486.0	691,487.0

Эх сурвалж: Аймгийн сонгуулийн зардлын тайлан

1.2.3 Захирамжийн дагуу аймгийн сонгуулийн хороонд 69,133.0 мянган төгрөг, сумдын сонгуулийн хороонд 622,354.0 мянган төгрөг, нийт **691,487.0** мянган төгрөгийг хуваарилсан байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 3. Аймаг, сумдын сонгуулийн хороонд олгосон санхүүжилт /мянган төгрөг/

№	Аймаг, сумын нэр	Сумын сонгуулийн хорооны тоо	Санал авах байрны тоо	Төлөвлөгөө	Олгосон	Дутуу олгосон
1	Алтанбулаг	1	3	31,796.0	31,416.00	380.0
2	Баруунбүрэн	1	3	31,484.0	31,104.00	380.0
3	Баянгол	1	3	32,566.0	32,186.00	380.0
4	Ерөө	1	3	30,834.0	30,454.00	380.0
5	Жавхлант	1	1	14,542.0	14,002.00	540.0
6	Зүүнбүрэн	1	2	22,558.0	22,098.00	460.0
7	Мандал	1	15	131,242.0	130,962.00	280.0
8	Орхон	1	2	22,898.0	22,438.00	460.0
9	Орхонтуул	1	3	31,594.0	31,214.00	380.0
10	Сайхан	1	4	40,942.0	40,642.00	300.0

11	Сант	1	2	22,898.0	22,438.00	460.0
12	Сүхбаатар	1	12	103,556.0	103,556.00	-
13	Түшиг	1	1	14,802.0	14,262.00	540.0
14	Хушаат	1	1	14,562.0	14,022.00	540.0
15	Хүдэр	1	1	14,782.0	14,242.00	540.0
16	Цагааннуур	1	3	30,834.0	30,454.00	380.0
17	Шаамар	1	3	30,464.0	30,084.00	380.0
	Сумын дүн	17	62	622,354.0	615,574.0	6,780.0
18	Аймаг			69,133.0	69,133.0	-
	Дүн	17	62	691,487.0	684,707.0	6,780.0

Эх сурвалж: Аймгийн сонгуулийн зардлын тайлан

1.2.4 Сумдын сонгуулийн хороонд хуваарилсан санхүүжилтийг 6,780.0 мянган төгрөгөөр /16 суманд тус бүр 380.0-540.0 мянган төгрөг/ дутуу олгож, аймгийн сонгуулийн хорооны дансанд үлдээсэн байна.

1.3. Сонгогчийн болон итгэмжлэгдсэн ажилтны тоо, сумдын байршил зэрэг мэдээлэлд үндэслэн зардлын төсвийг хуваарилсан байна.

1.3.1 УБЕГ-ын даргын 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн А/24, 06 дугаар сарын 11-ний өдрийн А/104 дүгээр тушаалуудаар нийт 55,290.1 мянган төгрөгийн санхүүжилтийг сонгогчийн тоо, итгэмжлэгдсэн ажилтны тоо, сумдын байршил, хоорондын зайг үндэслэн Сэлэнгэ аймгийн УБХ-т хуваарилж, бүрэн санхүүжүүлсэн байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 4. УБЕГ-аас аймгийн УБХ-т хуваарилсан санхүүжилт

/мянган төгрөг/

№	Зардлын нэр	2024.02.15	2024.06.11	Нийт
1	Итгэмжлэгдсэн ажилтны урамшуулал	30,102.5		30,102.5
2	Сонгогчийн нэрсийн жагсаалт хэвлэх	3,051.6		3,051.6
3	Сонгогчийн нэрсийн жагсаалт хүргэх	1,912.0		1,912.0
4	Сургалтын зардал	9,068.0		9,068.0
5	Тоног төхөөрөмж тээвэрлэх багийн зардал	1,136.0		1,136.0
6	Тоног төхөөрөмж тээвэрлэх автобусны зардал	4,400.0		4,400.0
7	Сонгуулийн өдөр ажиллах шуурхай багийн зардал	300.0		300.0
8	Сонгуулийн тоног төхөөрөмжийн туршилтын зардал		5,320.0	5,320.0
	Нийт дүн	49,970.1	5,320.0	55,290.1

Эх сурвалж: УБХ-ийн зардлын тайлан

БҮЛЭГ 2. СУРГАЛТ, САНАЛЫН ХУУДАС, САНАЛ ТООЛОХ ТӨХӨӨРӨМЖ АВАХ, БУЦААН ХҮРГЭХ, АЛБАН ТОМИЛОЛТ ЗЭРЭГ ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛЭЭС ШАЛТГААЛАН НИЙТ ЗАРДАЛ 3.5 ХУВИАР ХЭМНЭГДЖЭЭ.

2.1. Аймгийн сонгуулийн хороо нь унааны болон томилолтын зардлыг хэтрүүлэн зарцуулсан байна.

2.1.1 СЕХ-ноос Сэлэнгэ аймгийн сонгуулийн хорооны төсвийг нийт **691,487.0** мянган төгрөгөөр баталж, хуваарилснаас **667,043.1** мянган төгрөгийг зарцуулж, **24,443.9** мянган төгрөгийг СЕХ-ны дансанд буцаан төвлөрүүлсэн байна. Аймаг, сумдын сонгуулийн хорооны төсвийн гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:

*Хүснэгт 5. Аймаг, сумдын сонгуулийн хорооны зардлын гүйцэтгэл /аймаг, сумдаар/
/мянган төгрөг/*

№	Сумын нэр	Сумын сонгуулийн хорооны тоо	Санал авах байрны тоо	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт/хэмнэлт
1	Алтанбулаг	1	3	31,796.0	31,416.0	(380.0)
2	Баруунбүрэн	1	3	31,484.0	31,104.0	(380.0)
3	Баянгол	1	3	32,566.0	32,186.0	(380.0)
4	Ерөө	1	3	30,834.0	30,454.0	(380.0)
5	Жавхлант	1	1	14,542.0	14,002.0	(540.0)
6	Зүүнбүрэн	1	2	22,558.0	22,098.0	(460.0)
7	Мандал	1	15	131,242.0	130,962.0	(280.0)
8	Орхон	1	2	22,898.0	22,438.0	(460.0)
9	Орхонтуул	1	3	31,594.0	31,214.0	(380.0)
10	Сайхан	1	4	40,942.0	40,382.0	(560.0)
11	Сант	1	2	22,898.0	22,438.0	(460.0)
12	Сүхбаатар	1	12	103,556.0	103,556.0	-
13	Түшиг	1	1	14,802.0	14,262.0	(540.0)
14	Хушаат	1	1	14,562.0	14,022.0	(540.0)
15	Хүдэр	1	1	14,782.0	14,242.0	(540.0)
16	Цагааннуур	1	3	30,834.0	30,454.0	(380.0)
17	Шаамар	1	3	30,464.0	30,014.9	(449.1)
	Сумын дүн	17	62	622,354.0	615,244.9	(7,109.1)
18	Аймаг			69,133.0	51,798.2	(17,334.8)
	Нийт дүн	17	62	691,487.0	667,043.1	(24,443.9)

Эх сурвалж: Аймгийн сонгуулийн зардлын тайлан

2.1.2 Сумдын дүнгээр төлөвлөсөн зардлыг нийт 7,109.1 мянган төгрөгөөр хэмнэсэн нь Шаамар, Сайхан сумд зардлыг нийт 329.0 мянган төгрөгөөр хэмнэсэн болон аймгийн сонгуулийн хороо нь сумдын төлөвлөсөн зардлыг 6,780.0 мянган төгрөгөөр дутуу олгосноос тус тус шалтгаалсан байна.

2.1.3 Аймгийн сонгуулийн хороо нь нийт төлөвлөсөн зардлыг 17,334.8 мянган төгрөгөөр хэмнэсэн бөгөөд зардлын хэмнэлтэд дараах 3 төрлийн зардал голлон нөлөөлсөн байна. Үүнд:

- **Сургалтын зардал:** Аймгийн төвд 4 хоногоор сургалт хийхээр төлөвлөж, төсвийг баталсан боловч сургалтыг аймагт 2 хоног, Мандал суманд бүсчилсэн сургалт 1 удаа зохион байгуулсантай холбоотойгоор 10,974.8 мянган төгрөгөөр,
- **Саналын хуудас, санал тоолох төхөөрөмж авах, буцаан хүргэх зардал:** СЕХ-оос өндрөөр төлөвлөж ирсэн, зардлыг гүйцэтгэлээр тооцож олгосон,
- **Албан томилолтын зардал:** СЕХ-оос өндрөөр төлөвлөж ирсэн, зардлыг гүйцэтгэлээр тооцож олгосон гэх мэт.

2.1.4 Аудитаар аймаг, сумдын сонгуулийн хорооны зардлыг нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, төрийн сангийн дансны хуулгатай тулган шалгахад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Аймгийн сонгуулийн хороо нь төсвийн хуваарийг мөрдөлгүйгээр саналын хуудас, санал тоолох төхөөрөмжийг СЕХ-ноос авах, буцаан хүлээлгэж өгөх унааны зардлыг 1,112.0 мянган төгрөгөөр, томилолтын зардлыг 1,200.0 мянган төгрөгөөр тус тус хэтрүүлэн сумдад хуваарилсан төсвөөс санхүүжүүлсэн,
- Нийт 11 сум, 1,522.4 мянган төгрөгийн зардлыг зардал хооронд гүйлгэн зарцуулсан. Үүнд:
 - ✓ Алтанбулаг сум: Бичиг хэргийн зардлаас акустик хавтан, байр бэлтгэх зардлаас цаг худалдан авсан, засварын материал бэлтгэсэн зэргээр 150.0 мянган төгрөг,
 - ✓ Баруунбүрэн сум: Даамлын сургалтын шатахууны зардлаас сонгуулийн хорооны шатахуунд 150.0 мянган төгрөг,
 - ✓ Баянгол сум: Байр бэлтгэх зардлаас 75.0 мянган төгрөгийн үзгийн сав худалдан авсан, даамлын сургалтын шатахууны зардлаас сонгуулийн хорооны шатахуунд 98.8 мянган төгрөг,
 - ✓ Ерөө сум: Байр бэлтгэх зардлаас 22.0 мянган төгрөгийн уртасгагч худалдан авсан,
 - ✓ Жавхлант сум: Даамлын сургалтын шатахууны зардлаас сонгуулийн хорооны шатахуунд 23.0 мянган төгрөг зарцуулсан.
 - ✓ Зүүнбүрэн сум: Байр бэлтгэх зардлаас 62.5 мянган төгрөгийн бичиг хэргийн материал худалдан авсан,
 - ✓ Орхон сум: Байр бэлтгэх зардлаас 100.0 мянган төгрөгийн самбар, 191.0 мянган төгрөгийн засварын материал худалдан авсан,
 - ✓ Орхонтуул сум: Даамлын сургалтын шатахууны зардлаас сонгуулийн хорооны шатахуунд 155.2 мянган төгрөг зарцуулсан.
 - ✓ Сант сум: Бичиг хэргийн зардлыг 60.0 мянган төгрөгөөр, даамлын сургалтын шатахууны зардлаас сонгуулийн хорооны шатахуунд 95.2 мянган төгрөг зарцуулсан.
 - ✓ Түшиг сум: Бичиг хэргийн зардлаас 91.3 мянган төгрөгийн самбар, хаяг, байр бэлтгэх зардлаас 50.0 мянган төгрөгийн уртасгагч тус тус худалдан авсан,
 - ✓ Хүдэр сум: Байр бэлтгэх зардлаас 46.8 мянган төгрөгийн цайны зардал гаргаж, бичиг хэргийн зардлаас салфетка худалдан авсан, сурталчилгааны зардлыг 17.0 мянган төгрөгөөр хэтрүүлсэн, даамлын сургалтын шатахууны зардлаас сонгуулийн хорооны шатахуунд 102.6 мянган төгрөг зарцуулсан.

2.1.5 УБЕГ-ын даргын 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн А/24, 06 дугаар сарын 11-ний өдрийн А/104 дүгээр тушаалуудаар аймгийн УБХ-т **55,290.1** мянган төгрөгийн санхүүжилт хуваарилсныг нэмэлт санхүүжилтийн 100130012420 дугаар дансанд

төвлөрүүлж, зориулалтын дагуу зарцуулан хэмнэлт 4,250.5 мянган төгрөгийг татан төвлөрүүлсэн байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 6. УБХ-ийн зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

№	Зардлын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт/ хэмнэлт
1	Итгэмжлэгдсэн ажилтны урамшуулал	30,102.5	30,010.1	(92.5)
2	Сонгогчийн нэрсийн жагсаалт хэвлэх	3,051.6	1,207.0	(1,844.6)
3	Сонгогчийн нэрсийн жагсаалт хүргэх	1,912.0	1,912.0	
4	Сургалтын зардал	9,068.0	7,342.6	(1,725.5)
5	Тоног төхөөрөмж тээвэрлэх багийн зардал	1,136.0	1,068.0	(68.0)
6	Тоног төхөөрөмж тээвэрлэх автобусны зардал	4,400.0	4,400.0	
7	Сонгуулийн өдөр ажиллах шуурхай багийн зардал	300.0	300.0	
8	Сонгуулийн тоног төхөөрөмжийн туршилтын зардал	5,320.0	4,800.0	(520.0)
	Нийт дүн	55,290.1	51,039.6	(4,250.5)

Эх сурвалж: УБХ-ийн зардлын тайлан

2.1.6 Аймгийн УБХ нь томилолтын хуудаст санхүүгийн тооцооллыг хийж, нягтлан бодогчийн гарын үсгээр баталгаажуулалгүйгээр 8,474.0 мянган төгрөгийн томилолтын зардал тооцож, олгосон зөрчлийг аудитын явцад томилолтын хуудаст бичилт хийлгэж, залруулав.

2.2. Зардлын гүйцэтгэлийг СЕХ-ноос баталсан журмын дагуу тайлагнасан байна.

2.2.1 Аймаг, сумдын сонгуулийн хороо нь СЕХ-ны даргын 2021 оны А/17 дугаар захирамжаар баталсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын дагуу сонгуулийн зардлын тайланг гаргаж, нэгтгэсэн байна.

2.2.2 Аймгийн сонгуулийн хорооны нэгтгэж, тайлагнасан төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг зардлын ангиллаар харуулбал:

Хүснэгт 7. Сонгуулийн зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл /зардлын нэр төрлөөр/

/мянган төгрөг/

№	Зардлын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт/ хэмнэлт
1	Сонгуулийн дүн мэдээний маягт, хэвлэмэл хуудас хэвлүүлэх зардал	300.0	300.0	
2	Сонгуулийн бичиг баримт, техник хэрэгсэл болон сурталчилгааны материалыг аймаг, сумын сонгуулийн хороо, санал авах байранд хүргэх, буцаан татах авах зардал	38,288.0	33,820.0	(4,468.0)
3	Сонгуулийн автоматжуулсан систем ашиглахтай холбоотой гарах зардал	3,430.0	2,950.0	(480.0)
4	Санал авах байр бэлтгэх зардал	19,220.0	19,220.0	

5	Сонгуулийн байгууллагын ажилтан, МТБ-ийн гишүүн, даамал, нөөц даамлын сонгууль зохион байгуулахтай холбогдсон сургалт, сурталчилгааны зардал	37,873.0	26,898.2	(10,974.8)
6	Сонгуулийн байгууллагын ажилтан болон мэдээллийн технологийн багийн гишүүн, даамлын тухайн сонгуулийн байгууллагад ажилласан хугацааны мөнгөн урамшуулал, хоолны зардал	496,836.0	496,836.0	
7	Бичиг хэргийн зардал	10,990.0	10,932.0	(58.0)
8	Шуудан, холбооны зардал	12,850.0	12,825.0	(25.0)
9	Унааны зардал	54,180.0	54,170.0	(10.0)
10	Албан томилолтын зардал	11,568.0	3,140.0	(8,428.0)
11	Болзошгүй зардал	5,952.0	5,952.0	
Нийт дүн		691,487.0	667,043.1	(24,443.9)

Эх сурвалж: УБХ-ийн зардлын тайлан

2.2.3 УБЕГ-аас 8 төрлийн зардалд нийт **55,290.1** мянган төгрөгийн төсөв баталж, хуваарилсныг зориулалтын дагуу зарцуулж, үнэн зөв тайлагнасан байна.

2.3. Аймгийн сонгуулийн хорооноос сумын болон хэсгийн хороодод төсвийн зарцуулалт, тайлагналын талаар сургалт хийж, зөвлөмж хүргүүлсэн байна.

2.3.1 СЕХ-ны даргын 2021 оны А/17 дугаар захирамжаар баталсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын 3 дугаар зүйлийн 3.10-т “... аймаг, нийслэлийн сонгуулийн хороо нь сум, дүүргийн сонгуулийн хорооны, ... зардлын зарцуулалтад тус тус хяналт тавина” гэж заасан байна.

2.3.2 Аймгийн сонгуулийн хороо нь СЕХ-ноос ирүүлсэн зөвлөмжийн дагуу нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтыг бүрдүүлэх, санхүүжилтийг арвилан хэмнэлтэй зарцуулах, үнэн зөв тайлагнах, зарцуулалтад хяналт тавих, 2020 оны УИХ-ын сонгуулийн зардлын гүйцэтгэлд төрийн аудитын байгууллагаас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах зэрэг асуудлаар 1 удаагийн танхимын сургалтыг зохион байгуулсан байна.

2.3.3 Сумдын сонгуулийн хороодын нягтлан бодогчдын групп үүсгэн, 14 удаагийн мэдээ, мэдээлэл, үүрэг чиглэл, зөвлөмж өгч, “Сонгуулийн төсвийн зарцуулалтын тухай” зөвлөмжийг бэлтгэн файл хэлбэрээр бүх сумдад хүргүүлсэн байна.

2.3.4 Сайхан сумын сонгуулийн хорооны нягтлан бодогчийг сумын ЗДТГ-ын нярав гүйцэтгэсэн нь /Сумын ЗДТГ тухайн үед нягтлан бодогчгүй байсан/ СЕХ-ны даргын 2021 оны А/17 дугаар захирамжаар баталсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын 3.3.2-т заасан шалгуурыг хангаагүй байна.

2.3.5 Баянгол, Шаамар сумын сонгуулийн хороо нь тайлангийн товч танилцуулга, тодруулгыг ирүүлээгүй зөрчлийг аудитын явцад нөхөн бэлтгүүлж, зөрчлийг арилгав.

АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ

Аудитаар нийт 10,614.4 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, **3,834.4** мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, **6,780.0** мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүллээ. Үүнд:

Албан шаардлага:

- Аймгийн сонгуулийн хороо нь төсвийн хуваарийг мөрдөлгүйгээр саналын хуудас, санал тоолох төхөөрөмжийг СЕХ-ноос авах, буцаан хүлээлгэж өгөх унааны зардлыг 1,112.0 мянган төгрөгөөр, томилолтын зардлыг 1,200.0 мянган төгрөгөөр тус тус хэтрүүлэн сумдад хуваарилсан төсвөөс санхүүжүүлсэн,
- Нийт 11 сум, 1,522.4 мянган төгрөгийн зардлыг зардал хооронд гүйлгэн зарцуулсан.

Зөвлөмж:

- Аймгийн сонгуулийн хороо нь сумдын сонгуулийн хороонд хуваарилсан санхүүжилтийг 6,780.0 мянган төгрөгөөр /16 суманд тус бүр 380.0-540.0 мянган төгрөг/ дутуу олгосон.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Сонгогч, сонгууль зохион байгуулахад оролцох ажилтан, итгэмжлэгдсэн ажилтан, сум, хэсгийн хороодын тоо, тэдгээрийн байршил зэрэг мэдээлэлд үндэслэн аймгийн сонгуулийн хороо, УБХ-т зарцуулах зардлын төсвийг хуваарилсан байна.
- Аймгийн сонгуулийн хороо нь сумдын сонгуулийн хороонд хуваарилсан төсвийг дутуу олгосон байна.
- Аймаг, сумдын сонгуулийн хороо нь хуваарилсан төсвийг зардлын ангилал хооронд гүйлгэн зориулалт бусаар зарцуулсан байна.
- Сонгууль зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлийг холбогдох байгууллагууд журмын дагуу гаргаж, тайлагнасан байна.
- Сумдын сонгуулийн хороодод мэдээ, мэдээлэл, үүрэг чиглэл өгч, зөвлөмж бэлтгэн хүргүүлсэн боловч алдаа, зөрчил бүрэн арилаагүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүнд үндэслэн дор дурдсан албан тушаалтанд дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

Аймгийн сонгуулийн хорооны дарга Ө.Сувдаа, нягтлан бодогч П.Баярцэцэг нарт:

1. СЕХ-оос ирүүлсэн удирдамжийн дагуу зардлын тооцооллыг оновчтой, зөв хийж, аймаг, сумын сонгуулийн хороодод төсвийг хуваарилж, хуваарилсан төсвийг бүрэн олгох.
2. Сумдын сонгуулийн хорооны хуваарилагдсан төсвийн зарцуулалтад үр нөлөө бүхий хяналтыг хэрэгжүүлж, зардлын тайланг хуваарилсан төсөвтэй тулган хүлээж авах.


Аймгийн УБХ-ийн дарга Б.Саранчимэг, нягтлан бодогч М.Мягмар нарт:

1. Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтын бүрдлийг бүрэн хангасны үндсэн дээр ажил, гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгаж байх.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

Б.БАТМӨНХ

Т.БОЛОР